



# **ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ**

---

**2020 оны 37 болон 38 дэх долоо хоног**

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 9-р сарын 3-аас 9-р сарын 18-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 23 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 9-р сарын 16-ны тайландаа дэлхийн эдийн засаг 2020 онд 4.5 хувиар агшихаар, 2021 онд 5.0 хувийн өсөлттэй байхаар төсөөлжээ. Энэ нь өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад 2020 онд 1.5 нэгж хувиар сайжирсан, 2021 онд 0.2 нэгж хувиар муудсан төсөөлөл юм. Энэ оны 2-р хагасаас хөл хорио аажмаар суларч, үйлдвэрлэл, өрхийн хэрэглээ сэргэж байгаа нь төсөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад БНХАУ, АНУ, Евро бүсийн өсөлтийн төлөв сайжирсан бол Энэтхэг, Мексик, Өмнөд Африкийн өсөлтийн төлөв муудсан байна. Төсөөлөлд 2021 онд улс орнуудад вирусийн тархалт үргэлжлэх хэдий ч, оны эцэс рүү вакцин гарахаар таамагласан бөгөөд хэрэв цар тахлын дэгдэлт хүчтэй байвал дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд суурь төсөөллөөс 2-3 нэгж хувиар бага байх, хөрөнгө оруулалт сул, ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байж болзошгүйг анхааруулжээ.

Global Forecast Summary

CO	Annual Average 2015-2019	2019	2020F	2021F	2022F
<b>GDP Growth</b>					
US	2.5	2.2	-4.6	4.0	3.0
Eurozone	2.0	1.3	-9.0	5.5	3.2
China	6.7	6.1	2.7	7.7	5.5
Japan	1.0	0.7	-5.3	3.3	1.2
UK	1.8	1.5	-11.5	4.0	3.3
Developed*	2.0	1.6	-6.3	4.3	2.8
Emerging**	4.7	4.4	-1.3	6.6	4.7
World*	3.0	2.6	-4.4	5.2	3.6
<b>Inflation (end of period)</b>					
US	1.5	2.3	0.6	0.7	1.2
Eurozone	0.8	1.3	-0.6	0.8	1.3
China	1.8	4.5	2.0	1.6	2.0
Japan	1.0	0.8	-0.1	0.5	0.8
UK	1.5	1.3	0.4	1.9	1.6

#### *Fitch Ratings-ийн Дэлхийн эдийн засгийн төсөөлөл*

- “Fitch Ratings” улирал бүр нийтэлдэг “Глобал Эдийн Засгийн Төлөв” тайлангаа 9 дүгээр сарын байдлаар шинэчилж, дэлхийн эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар сайжруулан 4.4 хувиар агших төсөөллийг танилцуулав (Зураг 1). Дэлхийн эдийн засаг 2020 оны эхний хагаст 10 хувиар агшсан бөгөөд КОВИД-19-ийн тархалт үргэлжилж байгаа хэдий ч, эдийн засаг 4 дүгээр сараас хойш төсөөллөөс хурдтай сэргэж байна гэж үзжээ. Мөн энэ удаагийн тайланд Fitch Ratings БНХАУ болон АНУ-ын эдийн засгийн төлөвийг сайжруулсан бол Евро бүс, Их Британи болон хөгжиж буй орнуудын эдийн

засгийн төлөвийг бууруулсан байна. Тодруулбал, АНУ-ын эдийн засаг II улиралд 9.1 хувиар агшиж, III улиралд эдийн засгийн сэргэлт таамаглалаас хурдтай байх төлөвтэй тул 2020 оны төлөвийг өмнөх төсөөллөөс 1 нэгж хувиар сайжруулж 4.6 хувийн агшилттай байхаар төсөөлжээ. БНХАУ-ын эдийн засаг II улиралд өмнөх улирлаас 11.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өссөн нь төсөөллөөс өндөр байснаар 2020 оны өсөлтийг өмнөх төсөөллөөс 1.5 нэгж хувиар өсгөж 2.7 хувь байхаар тооцоолжээ. Харин Евро бүсийн эдийн засаг II улиралд түүхэн дээд хэмжээгээр буюу 12.1 хувиар агшсан нь 2020 оны төсөөллийг өмнөх төсөөллөөс 1 нэгж хувиар муутгаж 9 хувийн агшилттай байхаар тооцоход нөлөөллөө.

- **Холбооны Нөөцийн банк 9 дүгээр сарын 16-ны ээлжит хурлаар 2023 оныг дуустал бодлогын хүүгээ 0 хувь орчимд хадгалахаа мэдэгдлээ.** ХНБ дунджаар 2 хувийн инфляцыг онилох шинэчилсэн мөнгөний бодлогын стратегийг танилцуулснаас хойшхи эхний хурал байв. Хурлын үеэр ХНБ 2020 оны Америкийн өсөлтийг -6.5%-аас -3.7% болгон, ажилгүйдлийн түвшнийг 9.3%-аас 7.6% болгон сайжруулав. Эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлт сүүлийн саруудад эрчимжиж байгаа ч оны эхэн үеийн түвшнээс доогуур хэвээр байна. Эрэлт сул, газрын тосны үнэ мэдэгдэхүйц буурсан нь хэрэглээний үнийн индексийг бууруулжээ. ХНБ хямралын нөлөөг зөөлрүүлэх зорилгоор сард \$120 тэрбумын актив хөрөнгө худалдан авах хөтөлбөрөө эдийн засгийг бүрэн сэргэтэл одоогийн хэмжээгээр үргэлжлүүлэхээ мэдэгдэв. Тус хурлаар ХНБ хүндрэлийн үед АНУ-ын эдийн засгийг дэмжихэд бодлогын бүхий л арга хэрэгслийг ашиглаж, ажил эрхлэлт, үнийн тогтвортой байдлыг зохих түвшинд хангахыг зорино гэсэн байна. Түүнчлэн, дан ганц мөнгөний

бодлогоор эдийн засгийг сэргээх аргагүй тул сангийн бодлого чухал хэвээр байгааг онцлов.

- **Энэ оны 8-р сард АНУ-ын ажил эрхлэлт хүлээлтээс даван өсч, ажилгүйдлийн түвшин хурдтай буурчээ.** Ажилгүйдлийн нэмэлт орлогын багц хөтөлбөр 7-р сарын сүүлээр дууссантай холбоотойгоор 8-р сард иргэдийн орлого их хэмжээгээр буурч, үүнийг дагаад өрхийн зарлага, ажил эрхлэлт буурах хүлээлттэй байсан ч ажил эрхлэлт ийнхүү хүлээлтээс давсан үр дүн гарчээ. АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал 8-р сард өмнөх сараас сайжирсан ч өмнөх оны түвшинд хүрч бүрэн сэргэх харахан болоогүй байна. Тухайлбал, ажиллах хүчний тоо 2019 оны 8-р сард 163.9 сая байсан бол 2020 оны 8-р сард 160.8 сая болж буурсан. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үед 63.2 хувь байсан бол энэ оны 8-р сард 61.7 хувьд хүрч буураад байна. Ажил эрхлэлтийн судалгааг байгууллагууд болон өрхүүд гэсэн хоёр бүлгээр авч үзвэл:
  - а. Байгууллагуудын судалгааны үр дүнд шинэ ажлын байр 6-р сард 4.8 сая, 7-р сард 1.7 сая байсан бол 8-р сард нийт 1.37 сая болж буурсан байна. Үүнээс 238 мянган ажлын байр нь дараа сард байхгүй болох түр хугацааны ажлын байрнууд бөгөөд эдгээрийг хасч тооцвол 8-р сард нийт 1.13 сая шинэ ажлын байр бий болов. Мөн ажил эрхлэлт өмнөх оноос 316 мянган хүнээр өссөн нь хүн амын өсөлтийг нөхөх хангалттай өсөлт биш хэдий ч хүлээлтээс давсан үзүүлэлт юм.
  - б. Өрхүүдийн түүвэр судалгааны үр дүнд олон иргэн ажилдаа эргэж орсон эсвэл ажил хайж байгаа нөхцөл байдалтай байна. Ажиллах хүчинд хамаарах насанд хүрэгчдийн хүн амд эзлэх хувь 8-р сард өмнөх сараас өссөн байна. Ихэнх шинээр



ажил хайгчид ажлын байраа олсон бөгөөд энэ нь ажилгүйдлийн түвшин 8-р сард өмнөх сараас 1.8 нэгж хувиар буурч 8.4 хувьд хүрэхэд нөлөөллөө.

- **Европын Төв банкны Удирдах Зөвлөлийн гишүүд 9-р сарын 10-ны өдөр хуралдаж, Төв банкны бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдвэрлэв.** Мөн инфляцын төсөөллийг 2 хувьд дөхөх хүртэл хүүг нам дор түвшинд хадгалах зэрэгцээ, ААН-ийн санхүүгийн дарамтыг бууруулах зорилготой бонд худалдаж авах хөтөлбөрийн дүнг 1.35 орчим их наяд евро хэвээр үлдээжээ. Евро бүсийн эдийн засаг оны эхний хагаст 15.1% агшсаны дараа эдийн засагт сэргэлт ажиглагдан 3-р улиралд 8.4%, 4-р улиралд 3.1% өссөнөөр 2020 онд 8%-аар агшихаар байна гэж Төв банк төсөөлж байна. Евро бүсэд аж үйлдвэрлэл сэргэсэн ч хямралын өмнөх үеэс 11% доогуур хэвээр, 2019 оны эцэстэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 5 саяар их байна. Европын төв банкны багц бодлого өсөлтийг 1.3 нэгж хувиар, инфляцыг 0.8 нэгж хувиар нэмэгдүүлсэн хэдий ч хямралын үед сангийн бодлого, бүтцийн бодлого чухал байгааг ЕТБ-ны ерөнхийлөгч К.Лагард онцлов.
- **9-р сарын 11-ны өдөр Евро бүсийн 19 улсын Сангийн сайд нар Берлинд уулзалт хийж КОВИД-19 цар тахлын дараа эдийн засгийг хэрхэн дэмжих талаар хэлэлцлээ.** “Сангийн сайдууд сэргэлтийг дэмжихийн тулд санхүүгийн дэмжлэгээ үргэлжлүүлэхээ амласан” гэж Евро группийн дарга П.Донохо уулзалтын дараа мэдэгдэв. Мөн тэрээр Европын Холбооны засгийн газрууд цар тахал эхэлснээс хойш нийтдээ 3.7 их наяд гаруй еврог бүсийн эдийн засгийг дэмжихэд зарцуулахаар төсөвлөсний дээр 1.3 их наяд еврог нэмж тусгах магадлалтай байгааг мэдэгдлээ. Энэхүү нэмэлт 1.3 их наяд еврод Европын Холбооны

санхүүгийн зах зээл дээрээс буцалтгүй тусламж болон зээл хэлбэрээр авч, ойрын 3 жилд эдийн засгийн сэргэлтэд зарцуулах 750 тэрбум еврогийн багц багтжээ. Ингэснээр Засгийн газрын санхүүжилтүүд нийтдээ Европын Холбооны ДНБ-ий 36 хувьд хүрч нэмэгдэхээр байна. Харин Сангийн сайдууд одоогоор өрийн асуудлаас илүү эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт чухал байгааг онцоллоо.

- **Английн Төв банк 9 дүгээр сарын 17-ны хурлаар бодлогын хүүгээ 0.1 хувьд хэвээр үлдээлээ.** МБЗ мөнгөний бодлогын өнөөгийн төлөв зохистой хэвээр байна гэж дүгнэсэн бөгөөд Төв банк актив худалдан авах хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үлдэгдлийг 745 тэрбум фунт стерлинг байхаар хэвээр хадгалав. Их Британийн эдийн засагт сэргэлт ажиглагдаж байгаа ч ДНБ 2019 оны 4-р улиралтай харьцуулахад 11% доогуур түвшинд байна. Инфляц үргэлжлэн буурч зорилтот түвшнээс доогуур хадгалагдаж байгаа тул 2%-ийн түвшинд тогтвортой хадгалагдах хүртэл мөнгөний бодлогыг чангаруулахгүй гэдгийг төв банк онцлов.
- **Японы аж үйлдвэрлэл 7-р сард өмнөх сараас 8 хувиар өссөн нь сарын өсөлтийн дээд үзүүлэлт боллоо.** Гэсэн ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлийн түвшин 16.1 хувийн бууралттай байна. Сарын огцом өсөлтөд автомашины үйлдвэрлэл 7-р сард өмнөх сараас 38.5 хувиар өссөн нь голлон нөлөөллөө. Харин үйлдвэрлэлийн бусад салбар мөн хугацаанд 9 хувиар өссөн дүнтэй байна. Өмнөх сард хурдтай өсч байсан жижиглэнгийн худалдаа 7-р сард 3.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурчээ. Жижиглэн худалдааны борлуулалт салбар тус бүрт харилцан адилгүй байв. Тухайлбал, гол нэрийн барааны дэлгүүрүүдийн борлуулалт 5.2 хувиар, хувцасны дэлгүүрүүдийн



борлуулалт 20.9 хувиар, хүнсний дэлгүүрүүдийн борлуулалт 2.6 хувиар тус тус буурсан бол автомашины борлуулалт 7.8 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн итгэлийн индекс 8-р сард бага зэрэг буурч, хямралын өмнөх түвшнээс доогуур хэвээр байна. Японы шинэ ерөнхий сайд дотоод эрэлт, хэрэглээг сэргээхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж эдийн засагчид үзэж байна.

- **Японы Төв банк 9 дүгээр сарын 17-ны хуралдаанаар богино хугацаат бодлогын хүүг хасах 0.1 хувьд хэвээр хадгалж, 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөжийг 0 орчим хувьд хадгалах зорилгоор Японы ЗГ-ын бондын худалдан авалтад дээд хэмжээ тогтоохгүйгээр худалдан авахаа мэдэгдлээ. Гадаад, дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр аж үйлдвэрлэл сэргэж байгаа ч, компаниудын ашигт ажиллагаа буурсан хэвээр, хөрөнгө оруулалт агшиж байгааг онцлов. Хувийн хэрэглээ нэмэгдэж байгаа ч нийтийн хоол зэрэг зарим үйлчилгээний салбарын идэвхжил сул хэвээр байна. Хэдийгээр төсөв мөнгөний бодлого эдийн засагт дэмжлэг үзүүлж байгаа ч Ковид 19-ийн өрнөл эдийн засагт “маш өндөр**


тодорхой бус байдал” үүсгэж байгааг онцлов. Төв банк инфляцын 2%-ийн зорилтот түвшнийг тогтвортой хангатаг өгөөжийн муруйг удирдах (yield curve control) мөнгөний тоон болон чанарын зөөлөн бодлого (QQE)-ыг үргэлжлүүлэхээ мэдэгдлээ.

#### *Эх сурвалж:*

1. Deloitte, [Weekly global economic update September 2020](#)
2. Fitch, [Economic outlook September 2020](#)
3. ABC news, [Text of the Fed's statement after its meeting Wednesday](#)
4. U.S Bureau of Labor Statistics, [The employment situation —august 2020](#)
5. Trading economics, [japan industrial production](#)
6. Trading economics, [japan Retail-sales](#)
7. Trading economics, [japan consumer-confidence](#)
8. European central bank, [monetary policy decisions](#)
9. Reuters, [euro zone ministers pledge lasting fiscal support for economy](#)
10. Bank of England, [monetary policy summary and minutes](#)
11. OECD, [Economic outlook-2020](#)
12. Bank of Japan, [Statement on Monetary Policy](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт үргэлжилж байна**(Зураг 2.). Үл хөдлөх салбар дахь хөрөнгө оруулалт оны эхний 7 сард 1.6 хувиар агшсан бол эхний 8 сард 0.4 хувиар агшиж бууралт нь багасав.




*БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил*

Үүнд хувийн сектор дахь хөрөнгө оруулалт оны эхний 7 сард 5.7 хувиар агшсан бол эхний 8 сард 2.8 хувиар агшсан, дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалт оны эхний 7 сард 1 хувиар буурснаас эхний 8 сард 0.3 хувиар буурч тус тус бууралт нь багассан, оны эхнээс тээврийн салбар дахь үүнээс төмөр зам, хурдны замын хөрөнгө оруулалт 6-р сараас хурдтай нэмэгдсэн зэрэг нь өсөлтөд нөлөөлөв. **Аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл** 7-р сард 4.8 хувиар өссөн бол 8-р сард хүлээлтээс өндөр 5.6 хувь хүрч нэмэгдэв. Энэхүү сэргэлтэд төрийн өмчит болон хувийн аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл нэмэгдсэн бөгөөд үүнээс хувийн сектор дахь үйлдвэрлэл хүлээлтээс илүү өссөн нь голлон нөлөөлөв. **Жижиглэн худалдаа** 8-р сард хүлээлтээс өндрөөр 0.5 хувиар нэмэгдсэн нь оны анхны өсөлт байв. Өсөлтөд хэрэглээний үндсэн бүтээгдэхүүний өсөлт үргэлжилсэн, өдөр тутмын хэрэглээний бараа

бүтээгдэхүүний өсөлт огцом нэмэгдсэн, гоо сайхны бүтээгдэхүүн, үнэт эдлэл, автомашин гэх мэт зайлшгүй шаардлагатай бус бараа, бүтээгдэхүүний өсөлт 10 хувийг давсан зэрэг нь голлон нөлөөлөв. Мөн гэр ахуйн цахилгаан хэрэгслийн борлуулалт нэмэгдсэн зэрэг нь дотоод эрэлт идэвхжиж, БНХАУ-ын худалдан авагчдын итгэл сэргэж буйг илтгэж байна.

- **БНХАУ-ын нийгэм, хамгааллын, (aggregate social financing)** нэгдсэн санхүүжилт 8-р сард хүлээлтээс өндрөөр өмнөх сарын 1.69 их наяд юаниас 3.58 их наяд юань хүрч нэмэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар өссөн үзүүлэлт байв. БНХАУ-ын зээлийн тэлэлт үргэлжилж, цаашид эдийн засгийг тэтгэх зорилгоо дэмжлэгийн арга хэмжээнүүд үргэлжлэх хүлээлттэй. Юаниар шинээр олгосон зээлийн хэмжээ 7-р сард 992.7 тэрбум юань байсан бол 8-р сард 1.28 их наяд юань хүрч хүлээлтээс өндрөөр өсөв(Зураг 3).



*БНХАУ-ын нэгдсэн санхүүжилт*

Түүнчлэн ЗГ-ын бонд олголт огцом нэмэгдэж, 7-р сард 834 тэрбум юань байсан бол 8-р сард 1.38 их наяд юань

хүрч нэмэгдэв. Мөн корпорэйт бондын хэмжээ 7 сард 238 тэрбум юань байснаас өсч 363 тэрбум юаньд хүрсэн бол, банкуудын корпорэйт зээлийн хэмжээ өмнөх сарын 265 тэрбум юаниас 8-р сард 580 тэрбум юаньд хүрч тус тус нэмэгдлээ. Нийт корпорейт цэвэр зээлийн хэмжээ 579.9 тэрбум юаниар нэмэгдсэн бол дунд болон урт хугацааны корпорейт зээл 725.2 тэрбум юаниар өссөн байна. Харин M2 мөнгөний нийлүүлэлт 7-р сард өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар нэмэгдсэн бол 8-р сард 10.4 хувь хүрч бага зэрэг удаашрав. Сүүдэр банкны салбар дахь зээл 7-р сард 264.9 тэрбум юаниар буурч байсан бол 8-р сард 71 тэрбум юаниар нэмэгдсэн байна. Өрхүүдэд олгосон зээлийн хэмжээ энэ оны 7-р сард 757.8 тэрбум юань байсан бол 8-р сард 841.5 тэрбум юань болж нэмэгдсэн хэдий ч нийт зээлд эзлэх хэмжээ нь 7-р сарын түвшнээс буурсан байна. Цаашид эрх баригчид орон сууцны зах зээлд хөрөнгийн үнийн хөөсрөлт үүсгэхгүйн тулд энэхүү хэмжээг үргэлжлүүлэн бууруулах хүлээлттэй.

- **БНХАУ-ын инфляц 8-р сард хүнсний үнийн өсөлт саарсантай<sup>1</sup> холбоотойгоор өмнөх сараас буурав.** 2020 оны 7-р сард 2.7 хувиар нэмэгдсэн ХҮИ 8-р сард хүлээлтэд нийцтэй 2.4 хувиар нэмэгдэв.



<sup>1</sup> Хүнсний үнэ 7-р сард өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өссөн бол 8-р сард 11.2 хувиар өсч, өсөлтийн хурд саарав.

Хүнсний инфляцыг өсгөх нөлөө үзүүлсээр байгаа гахайн махны үнийн өсөлт 3-р сараас хойш алгуур саарсан хэвээр байна. Тухайлбал, гахайн махны үнэ 7-р сард өмнөх оны мөн үеэс 85.7 хувиар өссөн бол 8-р сард өсөлтийн эрч суларч 52.6 хувиар өсчээ. Газрын тосны үнэ буурснаар дотоодын шатахууны үнэ буурч, инфляцыг бууруулах нөлөө үзүүллээ. Суурь инфляц<sup>2</sup> сүүлийн 3 сарын хугацаанд 1.0 хувиас бага түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд 8-р сард 0.5 хувь байв. ХҮИ-ийн 37.5 хувийг бүрдүүлдэг үйлчилгээний үнэ 8-р сард өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан нь 2010 оны хамгийн анхны бууралт болов.

- **БНХАУ-ын үйлдвэрлэгчдийн үнийн индекс (ҮҮИ) 7-р сард 2.4 хувиар буурсан бол 8-р сард хүлээлтээс бага зэрэг дээгүүр буюу 2.0 хувиар буурав.** Төмрийн хүдрийн үнэ 7-р сард өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар, 8-р сард 2.5 хувиар буурав. Газрын тос, байгалийн хийн үнэ 7-р сард өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар, 8-р сард 25.2 хувиар буурсан боловч газрын тосны үнэ эргээд сэргэж эхэллээ.

#### Эх сурвалж:

1. China Preview: PPI Deflation may have eased further in August, Bloomberg
2. China React: Consumers start to join the production recovery, Bloomberg
3. China Preview: Activity Data set to show recovery has legs, Bloomberg
4. China React: Strong credit but unlikely swing PBOC stance, Bloomberg
5. China Commodities Today, Bloomberg
6. China React: Slowing inflation opens up room for PBOC easing, Bloomberg

<sup>2</sup> Суурь инфляцд хүнсний үнэ болон эрчим хүчний хэрэглээний үнэ ороогүй.

### 3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр хуралдан (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 8 хувьд хүргэх; (2) урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргалаа. Энэхүү шийдвэр нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно. Тухайн шийдвэр, арга хэмжээ нь инфляцын зорилтыг хангаж, эдийн засгийн уналтыг сааруулан, улмаар сэргэлтийг дэмжинэ.

Түүнчлэн Монголбанк, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хооронд хамтран ажиллах гэрээг өнөөдөр байгууллаа. Гэрээг байгуулан

ажилласнаар тус газраас нэвтрүүлж буй E-Mongolia цахим порталаар дамжих бүхий л төрийн үйлчилгээний гүйлгээ Монголбанкаар дамжин төлөгдөх боломж бүрдэх ба энэхүү томоохон төсөл амжилттай хэрэгжих үндэс суурь болох юм. Өөрөөр хэлбэл 180 орчим төрлийн төрийн үйлчилгээний төлбөр Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн системд боловсруулагдаж, тухайн агшин бүрд харилцагчийн гүйлгээ баталгаажиж, гүйлгээ нь бодит цагийн горимоор Төрийн сангийн газрын дансанд тусна.

Цаашилбал, Монголбанк нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Төлбөрийн картын системийг энэ ондоо багтаан бүрэн нэвтрүүлэх, мөн үндэсний төлбөрийн EMV chip стандарт бүхий Т картыг ойрын хугацаанд нийлүүлэх зорилт тавин ажиллаж байна.



#### 4 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс **3.7%**, өмнөх оны мөн үеэс **6.9%**-иар сулраад байна /2020.09.17-ны байдлаар/.
- ТОП-20 индексийн үзүүлэлт **17,154** болж өмнөх оны мөн үеэс 11.8%-иар буураад байгаа боловч сүүлийн 14 хоногийн хугацаанд харьцангуй тогтвортой байна /2020.09.17-ны байдлаар/.

14 ХОНОГИЙН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны	Өөрчлөлт	Өсөлт
		/2020.09.17/	/2020.09.03/	/2019.09.17/	/2020.09.03- 2020.09.17/	/өмнөх оны мөн үе/
<b>Валютын урсгал болон ханш</b>						
Ам.долларын ханш	₮	2,854.6	2,853.4	2,669.6	1.2	6.9%
<b>Хөрөнгийн зах</b>						
ТОП-20 индекс		17,154.7	17,068.9	19,449.8	85.8	-11.8%
<b>МУ-ын бондуудын өгөөж</b>						
Монгол 2021 - МАЗАЛАЙ	%	4.2	3.8	4.8	0.4	-12.3%
Монгол 2022 - ЧИНГИС	%	4.2	3.8	4.7	0.3	-11.9%
ХХБ САМУРАЙ	%	1.1	1.3	0.5	-0.2	107.3%
Монгол 2024 - Хуралдай	%	4.9	4.7	5.5	0.2	-11.7%
Монгол 2023 - Гэрэгэ	%	4.3	4.1	5.0	0.2	-14.0%
МУХБ	%	5.4	5.4	6.5	0.0	-16.5%
МИК	%	12.0	13.1	10.2	-1.1	17.4%

**Тайлбар:** Хүснэгтэд 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаарх хамгийн сүүлийн үеийн тоон мэдээг тусгасан бөгөөд зарим тоон мэдээ нь яг тус өдрийнх биш байна

#### ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ СУУРЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 2020 оны 8 дугаар сарын байдлаар **79.1%**-тай, нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө **83.1%**-тай биелсэн буюу төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 20.9%-иар, төсвийн зарлага төлөвлөснөөс 16.9%-иар буурсан байна.
- 2020 оны 8 дугаар сарын байдлаар гадаад худалдааны эргэлт **7,932.1 сая ам.доллар** гарч, тэнцэл **1025.7 сая ам.долларын ашигтай** гарлаа.
- Зөвхөн 8 дугаар сард 690.2 сая ам.долларын экспорт, 511.2 сая ам.долларын импорт хийсэн байна.
- 2020 оны 8 дугаар сарын инфляц улсын хэмжээнд **2.1%**, Улаанбаатар хотын хэмжээнд **1.7%** гарлаа.
- Зээл олголтын хэмжээ 7 дугаар сард 1.88 их наяд төгрөг байсан нь 8 дугаар сард 1.57 их наяд төгрөг болж **16.6%**-иар, зээл төлөлт 1.81 их наяд төгрөгөөс 1.51 их наяд төгрөг болж **16.8%**-иар буурсан байна.




ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	САРЫН МЭДЭЭ			Өөрчлөлт /2020.07- 2020.08/	Өсөлт /өмнөх оны мөн үе/
		Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе		
		/2020.08/	/2020.07/	/2019.08/		
<b>Монгол Улсын нэгдсэн төсөв</b>						
<b>Орлого</b>						
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	тэрбум ₮	5,699.4	4,900.3	6,876.3	16.3%	-17.1%
Татварын орлого	тэрбум ₮	5,160.1	4,495.6	6,248.9	14.8%	-17.4%
Татварын бус орлого	тэрбум ₮	539.3	404.7	627.3	33.3%	-14.0%
<b>Зарлага</b>						
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	тэрбум ₮	8,356.0	7,365.9	6,326.5	13.4%	32.1%
Урсгал зардал	тэрбум ₮	6,590.4	5,852.8	5,065.8	12.6%	30.1%
Хөрөнгийн зардал	тэрбум ₮	1,756.1	1,481.7	1,126.4	18.5%	55.9%
Цэвэр зээл	тэрбум ₮	9.5	31.3	134.3	-69.7%	-92.9%
<b>Гадаад худалдаа*</b>						
Худалдааны эргэлт	сая \$	7,932.1	7,244.3	9,478.4	9.5%	-16.3%
Экспорт	сая \$	4,478.9	4,055.2	5,387.1	10.4%	-16.9%
Импорт	сая \$	3,453.2	3,189.1	4,091.3	8.3%	-15.6%
Худалдааны тэнцэл	сая \$	1,025.7	866.0	1,295.8	18.4%	-20.8%
<b>Инфляц</b>						
Жилийн инфляц /Улс/	%	2.1	3.4	8.9	-38.2%	-76.4%
Жилийн инфляц /УБ хот/	%	1.7	3.2	10.5	-46.9%	-83.8%
<b>Банкны зээлийн тайлан</b>						
<b>Зээлийн хэмжээ</b>						
Олгосон зээл /түхэйн сард/	тэрбум ₮	1,571.6	1,884.3	1,786.7	-16.6%	-12.0%
Төлөгдсөн зээл /түхэйн сард/	тэрбум ₮	1,505.3	1,808.5	1,702.7	-16.8%	-11.6%
Зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	17,097.6	17,022.9	17,285.5	0.4%	-1.1%

\* Гадаад худалдааны мэдээ нь 15 хоногийн давтамжтай байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2020.08/:

Зураг 1. Татварын орлогын задаргаа, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 1. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж, 1 дүгээр улирал

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Татварын орлого	6,466,602.5	5,160,121.0	79.8%	(1,306,481.5)
Татварын бус орлого	741,045.1	539,303.6	72.8%	(201,741.6)
Нийт орлого ба тусламжийн дүн	7,207,647.6	5,699,424.6	79.1%	(1,508,223.0)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 2. Нийт зарлага ба цэвэр зээл


	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Урсгал зардал	7,366,427.7	6,590,386.5	89.5%	(776,041.2)
Хөрөнгийн зардал	2,584,704.6	1,756,050.6	67.9%	(828,654.0)
Цэвэр зээл	108,356.7	9,513.8	8.8%	(98,842.9)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	10,059,489.0	8,355,950.9	83.1%	(1,703,538.1)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк



Гадаад худалдаа /2020.08/:

Зураг 2. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар


Зураг 3. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Инфляц /2020.08/:


Зураг 4. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээлийн тайлан /2020.08/:

Зураг 5. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан



Эх сурвалж: Монголбанк


Хөрөнгийн зах /2020.09.17/:

Зураг 6. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Зураг 7. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

5

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/09/11	Өөрчлөлт					
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	6770.25	0.7%	0.1%	6.8%	10.6%	14.5%	БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдаж, улс орнуудын хөл хорио суларсан, эрэлт нэмэгдсэн, нөөц буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
<b>Коксжих нүүрс</b>	115.07	-	-	-	-	-20.8%	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
<b>Төмрийн хүдэр</b>	125.8	0.0%	-0.3%	6.1%	35.9%	30.3%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн сэргэлт сүүлийн 4 сар үргэлжилж, сар бүр 90 сая тонноос илүүг үйлдвэрлэсэн, боомтууд дээрх нөөц нэмэгдэж буй, хөл хорионы улмаас Бразилын нийлүүлэлт буурахаар байгаа хэдий ч энэ нь богино хугацаанд шийдвэрлэгдэх хүлээлтэй тул үнийн өсөлт хадгалагдав.
<b>Алт</b>	1940.5	0.8%	1.2%	0.6%	28.1%	30.6%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
<b>Газрын тос (Брент)</b>	39.8	-0.6%	-5.7%	-11.6%	-40.2%	-34.2%	“Lara” хар шуурганы нөлөөгөөр зогссон байсан газрын тос боловсруулах зарим үйлдвэрүүд эргэн ажиллаж эхэлсэн, АНУ-д нөөц өмнөх долоо хоногт хадгалагдсан, КОВИД-19-ийн тархалт буурахгүй нэмэгдсээр буй нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос буурав.